

Гадаад иргэдэд зориулсан Hello work ашиглах шалгах хуудас

~Ажлаас гарах гэж байгаа хүн/Ажлаас гараад шинэ ажил хайж байгаа хүнд~

Японы засгийн газраас хүргэх мэдээлэл байна.
Чухал асуудал тул, дараах зүйлсийг зайлшгүй шалгаж үзнэ үү.

Шалгах зүйл		<input checked="" type="checkbox"/>	P
STEP 1	Та ажлаас хэрхэн гарах вэ (гарсан бэ) тухай шалгаж үзнэ үү.		
	① Та ажлаас хэрхэн гарах вэ (гарсан бэ) гэдгээс шалтгаалан, компани янз бүрийн дүрэм дагаж мөрдөх ёстой байдаг. Мэдэж байгаа юу?		1
	② Эргэлзээтэй зүйл байвал, төрийн албан хаагчаас зөвлөгөө авна уу.		2
STEP 2	③ Ажлаас гарсны дараа, шууд бүртгүүлэх зүйл бас байдаг. Мэдэж байгаа юу?		3
	Hello work руу очоорой.		
	④ Hello work бол, төрийн албан хаагч таныг шинэ ажил хайхад туслах газар юм. Мэдэж байгаа юу?		5
	⑤ Ажилгүй болсон, ажлаас гарснаас хойш ажил олдохгүй байгаа тохиолдолд, амьжиргаандаа санаа зоволгүйгээр, шинэ ажил хайхыг дэмжсэн, “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг. Мэдэж байгаа юу?		6
STEP 3	⑥ Шууд ажиллах боломжгүй хүн ч, ажиллах боломжтой болсны дараа, “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг. Мэдэж байгаа юу?		9
	Шинэ ажил хайгаарай.		
	⑦ Оршин суух зөвшөөрлөөс хамааран, эрхэлж болох ажил ялгаатай байдаг. Мэдэж байгаа юу?		12
	⑧ Hello work-оор ажиллахыг хүсэж буй компаниа хайгаарай.		13
	⑨ Ажиллахыг хүсэж буй компанидаа өргөдөл гаргаж, ярилцлагад ороорой.		15
⑩ Ажил хурдан шийдэгдвэл “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг.		16	
STEP 4	Ажилд орох нь шийдэгдсэн үедээ, бүртгэлээ хийлгэнэ үү.		
	⑪ Шинэ компанийн хөдөлмөрийн нөхцлийг шалгаж үзнэ үү.		17
	⑫ Оршин суух зөвшөөрлийн бүртгэлээ хийлгэнэ үү.		17
	⑬ Ажил эхлэх үед, өөр бусад бүртгэл хийлгэх шаардлагатай байдаг. Мэдэж байгаа юу?		19



1

Та ажлаас хэрхэн гарах вэ (гарсан бэ) тухай шалгаж үзнэ үү.

- ① Та ажлаас хэрхэн гарах вэ (гарсан бэ) гэдгээс шалтгаалан, компани янз бүрийн дүрэм дагаж мөрдөх ёстой байдаг. Мэдэж байгаа юу?

Танай компани, таныг гадаад хүн гэдгээр шалтаглан, Япон хүнээс дорд хандах ёсгүй.

Компани, таныг **шалтгаангүйгээр халж болохгүй**. Компани таныг ажлаас халахыг хүсвэл, Япон хүнийг халахтай **адил дүрмийг** дагаж мөрдөх ёстой.

“Та яагаад ажлаас халагдах вэ” гэдэг талаар, таны болон компанийн байр суурь тохиролцоонд хүрсний дараа, халагдах мэдэгдэлд гарын үсгээ зураарай.



Компани таныг “ажлаас халах” тушаал гаргах тохиолдолд

- 1 Таныг халах тодорхой шалтгаан байхгүй бол, компани таныг ажлаас халах тушаал гаргаж болохгүй.

Түүнчлэн, дараах хугацаанд, компани таныг “ажлаас халах” тушаал гаргаж болохгүй.

- Ажилтай холбоотойгоор гэмтэл болон өвчнөөр амарч байх хугацаанд болон түүнээс хойш 30 хоногийн дотор
- Амаржихаас өмнөх, дараах амралтын хугацаанд (хүүхэд төрүүлэхээс өмнөх болон төрсний дараах амралтын хугацаа) болон түүнээс хойш 30 хоногийн дотор

- 2 Халах тушаал гаргах компани нь, халах өдрөөс 30-аас дээш хоногийн өмнө халах тухайгаа танд мэдэгдэнэ. 30 хоногт хүрэхгүй тохиолдолд, тэр хугацааны мөнгийг танд төлнө.

Гэрээ дуусах тохиолдолд

- 1 Компани нь, 3-с дээш удаа гэрээ сунгаж байгуулсан хүн болон 1 жилээс дээш урт хугацаанд үргэлжлүүлэн ажиллаж байгаа хүнтэй гэрээ дуусгавар болсны дараа шинээр гэрээ байгуулахгүй тохиолдолд, гэрээ дуусахаас 30 хоногийн өмнө “шинэ гэрээ хийхгүй” гэдгээ мэдэгдэх ёстой.

- 2 Гэрээ дуусгавар болсны дараа үргэлжлүүлээд тухайн газраа ажиллах болсон хүн шинэ гэрээ хийдэг. Компани нь, хэд хэдэн удаа гэрээ хийж тухайн компанийн ажлыг үргэлжлүүлэн хийж байгаа хүнтэй шалтгаан байхгүй бол, шинэ гэрээ хийх ёстой.

Өөрийн хүсэлтээр ажлаас гарах тохиолдолд

- “Хөдөлмөрийн дотоод журам” (компанийн дүрэм)-д заасан хоногийн (заагаагүй бол 2 долоо хоногийн өмнө) өмнө “ажлаас гармаар байна” гэдгээ компани болон дээд удирдлагадаа хэлнэ.
- Гэрээнд хэдий хугацаа хүртэл ажиллах талаар заасан байвал, гэрээний хугацааны дундуур ажлаас гарч болохгүй. Хүндэтгэх шалтгаан байгаа тохиолдолд компанитайгаа зөвлөлдөнө.

② Эргэлзээтэй зүйл байвал, төрийн албан хаагчаас зөвлөгөө авна уу.

- Компани таныг “ажлаас халах” тушаал гаргасан боловч компанийн дүрмийг мэдэхгүй тохиолдолд болон ажилласан боловч цалин аваагүй бол, юуны өмнө улсын “Гадаад ажилчдын зөвлөгөө авах булан” болон Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас зөвлөгөө авна уу. Компани мөнгөгүй болж дампуурсан тохиолдолд, төлөгдөөгүй цалингийн тодорхой хувийг улс нөхөн төлөх тогтолцоо байдаг.
- **Хөдөлмөрийн стандартын хяналтын газраас**, дараах асуудлаар зөвлөгөө авч болно.



- Хөдөлмөрийн нөхцөл (цалин хөлс болон ажлын цаг, ажлын агуулга зэрэг, ажиллах үеийн амлалт).
- Хэрхэн “амралтын тэтгэмж (※1)”-ээ авах вэ?
- “Ээлжийн цалинтай амралт (※2)”-аа хэрхэн ашиглах вэ?
- Компани нь, компанид ажиллаж байгаа хүнийг ажлаас халах хүсэлтэй үед дагаж мөрдөх дүрэм.

※1 Компанийн хариуцлагаар, компани таныг “ажлаас амар” гэж хэлсэн тохиолдолд, компани танд төлөх мөнгийг хэлнэ.

※2 Та компаниас амралтаа авахыг хүссэн үед ашиглахад, амарсан ч гэсэн цалин авдаг амралтыг хэлнэ.

Хөдөлмөрийн нөхцлийн талаар зөвлөгөө авах бол мэдээллийг эндээс авна уу

▶▶ https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner_eng.html



③ Ажлаас гарсны дараа, шууд бүртгүүлэх зүйл бас байдаг. Мэдэж байгаа юу?

Ажлаас гарвал, дараах зүйлүүдийг анхаарна уу.

Гадаадын иргэн, харьяатын агентлаг (Regional Immigration Services Bureau)-т мэдэгдэл хүргүүлэх

Таны оршин суух зөвшөөрөл 12-р хуудасны ② болон ④ байх тохиолдолд (эрхлэх ажлын агуулгаас хамааран оршин суух зөвшөөрөл нь шийдэгддэг хүн)

Ажлаас гарсны дараа 14 хоногийн дотор, “Харьяалах байгууллагын тухай мэдэгдэл” гаргаж Гадаадын иргэн, харьяатын агентлагт мэдэгдэнэ.

Ажил эрхлэлтийн даатгалд бүртгүүлэх

Та “Ажил эрхлэлтийн даатгал”-д хамрагдсан тохиолдолд, ажил хайхад зориулж мөнгө авах боломжтой. **Hello work**-оос зөвлөгөө авна уу. (Дэлгэрэнгүйг 6-р хуудаснаас)

Эрүүл мэндийн даатгалд бүртгүүлэх

1 Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг компанид ажиллаж байсан бол

Ажлаас гарахад, өдий хүртэл хамрагдаж байсан компанийн эрүүл мэндийн даатгалын эрх байхгүй болно. “Эрүүл мэндийн даатгалын даатгуулагчийн дэвтэр (Даатгалын дэвтэр)”-ийг компанийн ажилтанд буцааж өгнө үү.

Компанийн эрүүл мэндийн даатгалын эрх байхгүй болоход, оршин сууж буй хот, дүүрэг, суурин, тосгоны улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдах болно. Бүртгэлийн тухайд, оршин сууж буй хот, дүүрэг, суурин, тосгоны хүлээн авах цонхноос асууна уу.

Түүнчлэн, өөрийн хүсэлтээр бус ажилгүйдэл (компани дампуурсан, ажлаас халсан зэрэг шалтгаанаар ажилгүй болсон тохиолдол зэрэг)-ийн үед, хүсэлт гаргавал даатгалын хураамж (татвар)-аас хөнгөлөх тохиолдол байдаг. Оршин суугаа хот, дүүрэг, суурин, тосгоны хүлээн авах цонхноос зөвлөгөө авна уу.

Мөн түүнчлэн, таны эрүүл мэндийн даатгалд даатгуулсан хугацаа нь (ажлаас халагдсан компанид ажиллаж байсан хугацаа) үргэлжилсэн 2 сараас дээш байх тохиолдолд, хүсвэл, өдийг хүртэлхтэй адил компанийн эрүүл мэндийн даатгалд үргэлжлүүлэн хамрагдах боломжтой (сайн дурын тасралтгүй даатгуулагчийн тогтолцоо). Энэ тохиолдолд, ажлаас гарсан өдрөөс хойш 21-н хоногийн дотор бүртгүүлэх ёстой. Бүртгүүлэх аргын талаар, өдий хүртэл хамрагдаж байсан эрүүл мэндийн даатгалын даатгагчаас асууна уу (даатгагчийг компаниасаа асууж мэдэх болно).

Үндэсний эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн цахим хуудас, товхимол (Сайн дурын тасралтгүй даатгуулагчийн тогтолцооны тухай)

▶▶ <https://www.kyoukaikenpo.or.jp/g3/cat320/sb3180/>
<https://www.kyoukaikenpo.or.jp/g3/cat320/sb3180/1979-62524/>



2

(Компанийн эрүүл мэндийн даатгалд биш) оршин суугаа хот, дүүрэг, суурин, тосгоны улсын эрүүл мэндийн даатгалд хамрагддаг тохиолдолд

Ажлаас гарсан ч, үргэлжлүүлээд өдий хүртэлхтэй адил улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдах болно. Бүртгүүлэх шаардлагагүй.

Тэтгэврийн бүртгэл

1

Нийгмийн халамжийн тэтгэврийн даатгалд хамрагддаг компанид ажиллаж байсан тохиолдолд

Ажлаас гарахад, өдий хүртэл хамрагдаж байсан компанийн нийгмийн халамжийн тэтгэврийн даатгалын эрх байхгүй болно. 60-н нас хүрээгүй залуу хүн бол, шинээр “улсын тэтгэвэр”-т хамрагдана. Оршин суугаа хот, дүүрэг, суурин, тосгоны хүлээн авах цонхонд өргөдөл гаргана уу.

2

(Компаниараа биш) амьдарч буй хот, дүүрэг, суурин, тосгоны улсын тэтгэвэрт хамрагдаж байсан тохиолдолд

Ажлаас гарсан ч, тэр чигээрээ байна. Бүртгүүлэх шаардлагагүй.

Японы тэтгэврийн байгууллагын цахим хуудас, товхимол
(Ажил сольсон, ажлаас гарсан үеийн бүртгэл)

▶▶ <https://www.nenkin.go.jp/service/kokunen/kanyu/20121003.html>

<https://www.nenkin.go.jp/service/pamphlet/seido-shikumi.html>



2

Hello work руу очоорой.

④ Hello work бол, төрийн албан хаагч таныг шинэ ажил хайхад туслах газар юм. Мэдэж байгаа юу?

Hello work-н ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх газраас дараах үйлчилгээг бүгдийг үнэ төлбөргүйгээр авч болно.

1 Ажлын зөвлөгөө

Ажилд орох талаар төрөл бүрийн зөвлөгөө өгнө. Ямар ч асуудлаар **юуны өмнө зөвлөгөө өгөх газарт** хандаж зөвлөгөө авна уу.

2 Ажиллахыг хүсэж буй компаниа хайх (13-р хуудас руу)

Hello work нь, олон компаниудын ажлын байрны мэдээлэл (“ажлын байрны мэдээлэл” ... ажиллах хүсэлтэй хүн хайж буй компанийн мэдээлэл)-тэй байдаг. Ажлын байрны мэдээлэл нь, Hello work-н компьютер дээрээс ч харах боломжтой. Өөр Hello work дээр гарсан байгаа ажлын байрны мэдээллийг ч харж болно. Ухаалаг гар утаснаас мөн харах боломжтой. Хэрэв, компанийн хүсэлт болон таны хүсэлт тохирохгүй тохиолдолд, Hello work нь, компанид таны хүсэлтийг дамжуулах боломж бас байдаг.

3 Ажиллах хүсэлтэй компанид танилцуулах (15-р хуудас руу)

Та ажиллахыг хүсэж байгаа компаниа олбол, зөвлөгөө өгөх газарт очно уу. Ажилтны зүгээс, компани болон ажлын байрны гол зүйлийн талаар зөвлөгөө өгнө. Түүнчлэн, таныг компанийн ажилтантай ярилцлагад оруулахын тулд, ажилтны зүгээс компанийн ажилтантай утсаар ярьж, танд “танилцуулах бичиг” өгнө.

4 Ажил хайхыг дэмжих (15-р хуудас руу)

Hello work нь, намтар болон ажлын туршлага гэх мэт өргөдлийн баримт бичгийг зааж засаж өгөх болон ярилцлагын дэг жаяг, сэтгэл зүйн бэлтгэлийн талаар зөвлөгөө болон ярилцлагын дадлага, семинар мөн явуулдаг.

Hello work бүр дор бүрдээ өөр бусад төрөл бүрийн үйлчилгээг үзүүлж байгаа болно. Үйлчилгээний цэс, агуулгын талаар, гэрийнхээ ойролцоох Hello work-с асууна уу.

Гэрийнхээ ойролцоох Hello work-н мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000637894.pdf>



Орчуулагчтай Hello work бол мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000592865.pdf>



⑤ **Ажилгүй болсон, ажлаас гарснаас хойш ажил олдохгүй байгаа тохиолдолд, амьжиргаандаа санаа зоволгүйгээр, шинэ ажил хайхыг дэмжсэн, “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг. Мэдэж байгаа юу?**

“Ажил эрхлэлтийн даатгал” гэдэг нь, ажилгүй болсон, ажлаас гарсны дараа ажил олдохгүй байгаа тохиолдолд зориулсан даатгал юм. Амьжиргаандаа санаа зоволгүйгээр, шинэ ажил хайх боломж олгож, энэ даатгалаас мөнгө олгодог.

“Ажил эрхлэлтийн даатгал” авах бүртгэл дараах байдлаар хийгдэнэ.

1 Танд “Ажил эрхлэлтийн даатгалын даатгуулагчийн дэвтэр” (※1) байгаа бөгөөд 5-ын нөхцөл (7-р хуудсыг харна уу)-ийг хангаж байгаа тохиолдолд, та “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авахад (※2) хамрагдана.

(※1) 1 долоо хоногт 20-с дээш цаг ажиллаж, 31-с дээш хоног ажилласан бол, үндсэндээ компаниасаа авах боломжтой. Дэвтэр байхгүй тохиолдолд компаниасаа лавлана уу. Компани алдаа гаргаж, бүртгэл хийгдээгүй байсан гэж үзвэл, Hello work-с зөвлөгөө авч болно.

(※2) Өмнөх ажиллаж байсан цаг нь, 1 долоо хоногт 20 цаг хүрэхгүй хүн болон өдрөөр суралцдаг гадаад оюутан зэрэг нь үүнд хамаарахгүй.

2 Та “Ажил эрхлэлтийн даатгал”-д хамаарах тохиолдолд, ажлаас гарахдаа, компани танд “Ажлаас халагдсан тодорхойлолт”-д нэрийн дардас болон гарын үсэг зурна уу” гэж хэлнэ. “Ажлаас халагдсан тодорхойлолт”-д бичигдсэн цалин хөлсний мөнгөн дүн болон таны ажлаас халагдсан шалтгаан (? 10-р хуудас руу)-ыг алдаагүй зөв бичсэн эсэхийг нягталж үзнэ үү.

Та “илгээлтийн ажилтан (ажилтан илгээх компанитай гэрээ хийж өөр компанид ажилладаг хүн)” бол ажилтан илгээх компани ба ажиллаж байгаа компани хоорондын гэрээ дуусгавар болоогүй байхад, ажилтан илгээх компаниас гарах тохиолдолд, “ажилтан илгээх компани”-ийн зүгээс “Ажлаас халагдсан тодорхойлолт”-д нэрийн дардас болон гарын үсэг зурна уу” гэж хэлдэг. Та “ажилтан илгээх компани”-аас гарсан шалтгааныг алдаагүй зөв бичсэн эсэхийг нягтална уу.

3 Компани “Ажлаас халагдсан тодорхойлолт”-ыг Hello work-д өгөхөд, Hello work нь “Ажил эрхлэлтийн даатгалын даатгуулагчийн ажлаас халагдсан хуудас” (“Ажлаас халагдсан хуудас-1”, “Ажлаас халагдсан хуудас-2” гэдэг)-ыг компанид өгдөг. Компани нь, энэ “Ажлаас халагдсан хуудас-1”, “Ажлаас халагдсан хуудас-2”-г танд өгнө. Цалин хөлсний мөнгөн дүн болон ажлаас халагдсан шалтгаан (? 10-р хуудас руу)-г алдаагүй зөв бичсэн эсэхийг дахин нягтална уу. Алдаатай тохиолдолд, компанид мэдэгдэж, засуулж авна. Компани засаж өгөхгүй тохиолдолд, Hello work-с зөвлөгөө авна уу. Түүнчлэн, компани ажлаас халагдсан хуудсыг өгөхгүй тохиолдолд ч гэсэн, Hello work-с асууна уу.

Ажлаас халагдсан хуудас-1, Ажлаас халагдсан хуудас-2 нь ийм зүйл байна.


▶▶ https://www.hellowork.mhlw.go.jp/doc/info_1_e2_01.pdf
https://www.hellowork.mhlw.go.jp/doc/info_1_e7_01.pdf



4

Шууд ажиллах боломжтой хүн бол тэтгэмж авах эрхийн шийдвэр (танд мөнгө олгох эсэх тухай Hello work шийднэ) гаргуулах бүртгэл хийлгэнэ үү. (Шууд ажиллах боломжгүй хүн бол 9-р хуудас руу) Ажлаас гарсны дараа шууд бүртгэл хийлгэнэ үү. Мөнгө авах хугацаа нь, таны ажлаас гарсны дараа өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай шийдэгдэнэ. Hello work-д ирэх нь хоцорвол, авах мөнгөний хэмжээ багасна. Ажлаас гараад 1 жил өнгөрсний дараа Hello work руу ирлээ гэхэд, ямар ч мөнгө авч чадахгүй.

(Жишээ) Та уг нь “150 хоногт ногдох” мөнгө авах боломжтой байсан хэдий ч, бүртгэл хийлгэх нь оройтсон тохиолдолд, мөнгө олгохоор шийдвэр гарсан өдрөөс эхлэн, та **ажлаас гарсны дараа өдрөөс хойш 1 жил** өнгөрөхөд л мөнгө авч чадахгүй болно.



5

Мөнгө хүлээж авахын тулд, зарчмын хувьд, та **ажлаас гарсан өдрийн өмнөх 2 жилийн хугацаанд 12-с доошгүй сар даатгуулсан хугацаа (Ажил эрхлэлтийн даатгалд хамрагдсан хугацаа)**-тай байх шаардлагатай.

Гэвч, дараах тохиолдолд, та ажлаас гарсан өдрөөс өмнөх **1 жилийн дотор 6-с доошгүй сар** даатгуулсан хугацаатай байвал болно.

- Компани дампуурсан, ажлаас халагдсан зэрэг шалтгаанаар, та компаниас гарсан тохиолдолд (тусгай тэтгэмж авах эрхтэй хүн (? 10-р хуудас руу) болно.)
- Хугацаатай хөдөлмөрийн гэрээг сунгаагүй болон өөр бусад аргагүй шалтгаантай халагдсан тохиолдолд (тусгай шалтгаанаар халагдсан хүн (? 10-р хуудас руу) болно.)

6

Дараах баримт бичигтэйгээ, гэрийнхээ ойролцоох **Hello work**-д очиж, шинэ ажил хайх өргөдөл гаргана уу. (Ажил хайх хүсэлт 13-р хуудас руу) Таны гаргасан баримт бичгийг үзэж, Hello work тэтгэмж авах эрхийг нягталж, шийдвэрлэнэ.

【Hello work руу авч ирэх зүйл】

1. **Компаниас өгсөн ажлаас халагдсан хуудас-1** (Нэр болон банкны дансны дугаар зэргийг өөрөө бичнэ үү)
2. **Компаниас өгсөн Ажлаас халагдсан хуудас-2**
3. **My number**
 ※My number аваагүй тохиолдолд
 - ① My number-ийн мэдэгдэх карт болон My number бичигдсэн оршин суух үнэмлэхийн мэдээллийн тодорхойлолт
 - ② Оршин суугчийн үнэмлэх болон паспорт зэрэг зурагтай биеийн байцаалт бичиг баримт
4. **Нэрийн дардас** (Зөвхөн зөвшөөрлийн дардас. Дардас тэмдгээс өөр бусад)
5. **Зураг 2 ширхэг** (Сүүлийн үеийн зураг, цээж зураг, өндөр нь 3,0 см × өргөн нь 2,5 см)
6. **Банкны хадгаламжийн дэвтэр эсхүл банкны карт** (таны нэр бичээстэй зүйл)

7

Мөнгө авах тохиолдолд, Hello work дээр “Ажил эрхлэлтийн даатгалын танилцуулах уулзалт”-д оролцоно. Энд таныг мөнгө авах тодорхойлолт (“Ажил эрхлэлтийн даатгал авах эрхийн бичиг”) зэргийг олгоно. Түүнчлэн, ажилтан цаашдын бүртгэлийн ажиллагааг тайлбарлана.

Ажил эрхлэлтийн даатгал авах эрхийн бичиг гэдэг нь ийм зүйл байна.

▶▶ https://www.hellowork.mhlw.go.jp/doc/info_1_e5_02.pdf



8

Та Hello work болон хүний нөөцийн зуучлалын хувийн компани ашиглан, ажил хайлт (ажил хайх үйл ажиллагаа) явуулна. Зарчмын хувьд 4-н долоо хоногт 1 удаа Hello work руу ирж, “Ажилгүйдэл баталгаажуулах мэдүүлэг” бичиж, ажилтанд ажил хайх үйл ажиллагааны явц (※)-ыг тайлагнана. Таны ажилгүйдэлд байгаа нь (ажил байхгүй гэдэг нь) батлагдвал, 1 долоо хоног орчимд таны банкны дансанд мөнгө шилжүүлэгдэнэ. Хэзээнээс, хэдий хэмжээний гэдэг нь ажлаас гарсан шалтгаанаас хамаарч өөр байна.

(※) Мөнгө авахын тулд, “ажил хайх үйл ажиллагааны бодит гүйцэтгэл” гэж хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагааг 4-н долоо хоногийн хугацаанд 2-с дээш удаа явуулах шаардлагатай. “Ажил хайх үйл ажиллагааны бодит гүйцэтгэл” гэж хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагаа нь дараах болно.

- **Компанид өргөдөл гаргах**
- **Hello work болон хүний нөөцийн зуучлалын хувийн компаниас зөвлөгөө авч, компани танилцуулж авах**
- **Hello work болон хүний нөөцийн зуучлалын хувийн компаниас зохион байгуулах семинарт оролцох**
- **Компанийн танилцуулах уулзалтад оролцох**
- **Эрх авах шалгалт өгөх гэх мэт**

▶▶ https://www.hellowork.mhlw.go.jp/doc/info_1_e4_01.pdf



⑥ Шууд ажиллах боломжгүй хүн ч, ажиллах боломжтой болсны дараа, “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг. Мэдэж байгаа юу?

※Шууд ажиллах боломжтой хүн бол 6-р хуудас руу. Шууд бүртгүүлнэ үү.

1 Ажлаас гараад шууд ажиллах боломжгүй хүн ч гэсэн “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломжтой. Жишээлбэл, дараах хүмүүс, ажлаас гараад 31-н хоног болсны дараа, шууд Hello work руу очиж, “Тэтгэмж авах хугацааг сунгах хүсэлт”-ийг гаргана уу.

- ① Өвчин болон гэмтлийн шалтгаанаар ажиллаж чадахгүй байгаа
- ② Жирэмсэн, төрсөн, хүүхэд асрах (зөвхөн 3 нас хүртэл) зэрэг шалтгаанаар ажиллаж чадахгүй байгаа (үргүйдлийн эмчилгээ хамаарна)
- ③ Хамаатан садангаа асрах шалтгаанаар ажиллаж чадахгүй байгаа
- ④ 60-с дээш насны тэтгэвэр зэрэг шалтгаанаар ажлаас гарч, хэсэг хугацаанд амрах

2 Энэ хүсэлтийг гаргасан байхад, ажиллах боломжтой болж, ажил хайж эхэлсэн үед мөнгө авах боломжтой.





Тусгай тэтгэмж авах эрхтэй хүн, тусгай шалтгаанаар халагдсан гэдэг нь юу гэсэн үг вэ/Ажлаас гарсан шалтгаанаа нягтална үү

Хүмүүс ажлаас халагдах шалтгааны гол зүйлсийг танилцуулъя.

① Ажлаас халагдах	Компанийн шалтгаанаар, таныг “халах” тушаал гарсан тохиолдол
② Компани дампуурах	Компани дампуурч, байхгүй болох тул халагдсан тохиолдол
③ Бизнесийн эздийн санаачлагаар өөрийн хүсэлтээр халагдах өргөдөл гаргахыг хүсэх эсхүл ажлаас гарахыг санал болгох	Компаниас “ажлаас гарах уу?” гэж асуухад, та “за” гэж хэлсэн тохиолдол
④ Компанийн нөхцөл байдлаас шалтгаалан ажиллуулахаа болих (3-с дээш жил)	Хугацаатай гэрээг хэд хэдэн удаа сунгаж 3-с дээш жил нэг ижил компанид ажиллаж ирсэн боловч, компанийн шалтгаанаар, гэрээний хугацаа дуусах үед гэнэт сунгахгүй болсон тохиолдол
⑤ Компанийн нөхцөл байдлаас шалтгаалан ажиллуулахаа болих (3 хүртэл жил)	Хугацаатай гэрээгээр нэг ижил компанид ажиллаж байгаа хугацаа 3-н жил хүрэхгүй тохиолдолд, та гэрээ сунгахыг хүссэн боловч сунгаагүй тохиолдол
⑥ Хүндэтгэх шалтгааны улмаас өөрийн хүсэлтээр ажлаас гарсан	Өвчин болон гэмтэл, жирэмсэн болон хүүхэд асрах, гэр бүлээ асрах зэрэг гарцаагүй шалтгаанаар та хүсэлт гарган ажлаас гарсан тохиолдол
⑦ Өөр бусад гэрээний хугацаа дуусгавар болсон	Хугацаатай гэрээгээр, дараа нь гэрээ сунгахгүй гэдгийг та ч гэсэн мэдэж байгаад гэрээ сунгагдаагүй тохиолдол
⑧ Тэтгэвэрт гарах	“oo нас хүрэхэд тэтгэвэрт гарна” гэж тогтоосон насанд таны нас хүрсэн тохиолдол
⑨ Хатуу хариуцлага тооцож ажлаас халагдах	Сахилгын шийтгэл хүлээх зэрэг, таны буруутай үйлдлээр компани “халах” тушаал гаргасан тохиолдол
⑩ Хүндэтгэх шалтгаангүйгээр өөрийн хүсэлтээр ажлаас гарах	Өөрийн хүсэлтээр ажлаас гарах тохиолдол

“Тусгай тэтгэмж авах эрхтэй хүн”, “Тусгай шалтгаанаар халагдсан” гэдэг нь


■ **Тусгай тэтгэмж авах эрхтэй хүн** . . . Компани дампуурах, ажлаас халагдах зэрэг шалтгаанаар дахин ажил хайхад бэлдэх хугацаа байхгүйгээр ажлаа алдсан хүн (дээрх жишээн дээр бол ①~④ -т бичигдсэн хүн)

■ **Тусгай шалтгаанаар халагдсан** гэдэг нь, тусгай тэтгэмж авах эрхтэй хүнээс өөр бусад, хугацаатай хөдөлмөрийн гэрээг сунгаагүй, бусад гарцаагүй шалтгаанаар ажлаас гарсан хүн (дээрх жишээн дээр бол ⑤, ⑥-т бичигдсэн хүн)

“Тусгай тэтгэмж авах эрх”, “тусгай шалтгаанаар халагдсан”-д тооцогдох эсэхийг дүгнэх

Та тусгай тэтгэмж авах эрхтэй хүн, тусгай шалтгаанаар халагдсанд тооцогдох эсэхийг Hello work шийднэ. Та ажлаас гарсан шалтгаанаа үнэн гэдгийг нотлох баримт бичгийг гаргаж өгөх ёстой. Компанийн бодож буй “компаниас гарах шалтгаан” нь таны хэлж байгаагаас зөрүүтэй бол, Hello work танаас ирүүлсэн баримт бичиг болон компаниас ирүүлсэн баримт бичгийг хоёуланг нь үзэж, ажлаас гарсан шалтгааныг тодорхойлно.

Тэтгэмж авахад бүртгүүлэх



3

Шинэ ажил хайгаарай.

⑦ Оршин суух зөвшөөрлөөс хамааран, эрхэлж болох ажил ялгаатай байдаг. Мэдэж байгаа юу?

1 Оршин суух зөвшөөрлөөс шалтгаалан, Японд эрхлэх боломжтой ажил ялгаатай байдаг. Та оршин суугчийн үнэмлэхээ харж, оршин суух зөвшөөрлөө нягтална уу.

① Байнгын оршин суугч. Япон хүний гэр бүл зэрэг. байнгын оршин суугчийн гэр бүл зэрэг. суурин иргэдийн тухайд



Ямар ч ажил эрхэлж болно.

② Технологи. хүмүүнлэгийн ухааны ажил. олон улсын үүрэгт ажил. нарийн мэргэжлийн ажил. асаргаа. ур чадвар. тусгай ур чадвар зэрэг тохиолдолд



Ажил эрхлэх агуулгаас хамааран, оршин суух зөвшөөрөл шийдэгддэг.

(Жишээ 1) “Технологи, хүмүүнлэгийн ухааны ажил, олон улсын үүрэгт ажил”-ын хүн

- Их дээд сурууль болон Япон улсын дотоод дахь мэргэжлийн сургуульд мэргэшсэн дамжаа төгссөн байх
- Их дээд сургууль болон мэргэжлийн сургуульд **таны сонгож мэргэшсэн сэдэв нь ажиллах гэж буй ажил үүрэгтэй хамаарал бүхий** (※1) байх шаардлагатай. Их дээд сургуульд сонгож мэргэшсэн хичээлийн хамаарлын тухайд уян хатан (※2) дүгнэнэ. Та дипломоо төдийгүй, (авсан бүх кредит бичсэн) дүнгийн хүснэгтийг харж, хамааралтай эсэхийг нягтална уу.

※1 Хамаарал бүхий гэж хүлээн зөвшөөрөгдөх жишээ

- Инженерийн факультет төгссөн хүн, цахилгаан бараа үйлдвэрлэх компанид технологийн хөгжлийн ажил хийх
- Японы мэргэжлийн сургуулийн гоо сайхны ангийг төгссөн хүн, гоо сайхны бараа худалдаалах компанид, гоо сайхны бүтээгдэхүүний бүтээгдэхүүн хөгжил болон маркетингийн ажил хийх

※2 “Мэргэшсэн” гэдэг нэрнээс тэрхүү ажил үүрэгтэй шууд хамааралтай байгаа нь хүлээн зөвшөөрөгдөхгүй ч, таны сонгож суралцсан бүх “хичээл”-ийг нийтэд нь харж, ажиллах гэж буй ажил үүрэгт шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн эсэхийг дүгнэнэ. Түүнчлэн, одоо ажиллах гэж байгаа ажилд, өдий хүртэл хугацаанд 3-н жил ажилласан байгаа хүний тухайд, их дээд сургууль зэргийн “мэргэшсэн” гэдэгтэй нягт хамааралтай биш ажил байсан ч уян хатан дүгнэнэ.

(Жишээ 2) “Тусгай ур чадвар”-ын хүн

- Ур чадварын дадлагажигчийн 2-р зэргийг амжилттай дуусгасан хүн ⇒ Ур чадварын дадлага хийсэн ажилтай ижил ажилд
- Шалгалтанд тэнцсэн хүн ⇒ Тэнцсэн шалгалтын салбарт л ажиллах боломжтой. Ур чадварын дадлага хийгээгүй, шалгалтад тэнцээгүй салбарт ажиллах боломжгүй. Мөн түүнчлэн, барилга болон хөдөө аж ахуй зэрэг тусгайлсан 14-н салбараар хязгаарлана.

3 Гадаад оюутан, гэр бүлийн визтэй тохиолдолд



Гадаадын иргэн, харьяатын агентлагт “Эрхийн бус үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл”-ийн өргөдөл гаргаж, зөвшөөрөл авна уу. 1 долоо хоногт, 28-н цагаас хэтрэхгүй бол ажиллах боломжтой. Гадаад оюутан нь, хаврын амралт зэрэг сургуулийн урт амралтын үед, 1 өдөрт 8-н цагаас хэтрүүлэхгүйгээр ажиллах боломжтой. Түүнчлэн, гадаад оюутан бөгөөд удахгүй сургуулиа төгсөх хүн бол 2-н оршин суух зөвшөөрөл рүү өөрчлөх төлөвлөгөөтэй бөгөөд 2-д хамаарах агуулгаар ажиллах компанийг хайх боломжтой.

4 Ур чадварын дадлагын тохиолдолд



Зарчмын хувьд, Японд ирээд үргэлжид нэг л компанидаа ажиллана. Хэрэв, ажлаас гарах болбол, “Хянагч байгууллага” болон “Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага”-аас зөвлөгөө авч, шинэ компани олуулна уу. Гэхдээ, “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах тохиолдолд, Hello work-д бүртгүүлнэ.

5 Бусад оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд



Зарчмын хувьд ажиллаж болохгүй. Гэхдээ, 1 болон 2 руу оршин суух зөвшөөрөл өөрчлөгдөх төлөвлөгөөтэй байвал, ажиллах компаниа хайх боломжтой.

2

1, 2, 3-ийн оршин суух зөвшөөрөлтэй хүн, өөрийгөө ямар агуулгын ажил хийх боломжтой талаар тодорхойлолт авахыг хүсвэл, Гадаадын иргэн, харьяатын агентлагаас “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тодорхойлолт” гаргуулж авах боломжтой. Энэ тодорхойлолтыг шинэ компанидаа өгөх боломжтой.

8 Hello work-оор ажиллахыг хүсэж буй компаниа хайгаарай.

1

Hello work-оор ажил хайхын тулд, өргөдөл гаргана уу. Гэрийнхээ ойролцоох Hello work руу очно. “Ажил эрхлэлтийн даатгал”-ын мөнгө авах боломжтой (6-р хуудас руу). **Оршин суугчийн үнэмлэх болон паспорт**-оо авч ирнэ үү.

Гэрийнхээ ойролцоох Hello work-г эндээс хайх боломжтой.

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000637894.pdf>



Орчуулагчтай Hello work бол мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000592865.pdf>



2

Hello work-д байгаа “Ажлын байрны өргөдөл”-ийг бичих эсхүл ухаалаг утас болон Hello work-н компьютер дээр өөрийн мэдээллээ оруулж, зөвлөгөө өгөх цонхны ажилтнаас зөвлөгөө авна. Hello work нь, таны оршин суугчийн үнэмлэх болон паспортыг үзнэ. Таны оршин суух зөвшөөрөл ажиллах боломжтой байвал, “Hello work хүлээн авах хуудас”-ыг авах боломжтой. Хүлээн авах хуудас дээр таны “Ажлын байр хайх дугаар” бичигдсэн байна. Hello work руу очихдоо, хүлээн авсан “ Хүлээн авах хуудас”-ыг заавал авч ирнэ. Хүлээн авах хуудас байвал, өргөдөл гаргасан газраас өөр Hello work дээр ч, ажлын байрны мэдээлэл хайх боломжтой.

“Ажлын байрны өргөдөл” бичих зааврын мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.hellowork.mhlw.go.jp/doc/gaikokujinnyuusyokumousikomisyonokakikata.pdf>



(Япон хэл мэддэг хүн бол) Hello work дээр байгаа компьютер болон өөрийн компьютер эсхүл ухаалаг утаснаас түр бүртгэл хийлгэсний дараа, зөвлөгөө өгөх цонхон дээр ирж өргөдлөө бүртгүүлэх боломжтой.

▶▶ <https://kyushoku.hellowork.mhlw.go.jp/kyushoku/GEAA020020.do?action=initDisp&screenId=GEAA020020>

**3**

Ажлын байрны мэдээллийг Hello work-н зөвлөгөө өгөх цонхонд ирж хайлт хийлгэнэ. Хүлээж авсан “ажлын байрны санал”-ыг харж, өөрийн хүсэж буй ажлын байрыг хайна. “Ажлын байрны санал”-ыг харахад хүндрэлтэй тохиолдолд, Hello work-н ажилтнаас зөвлөгөө авч, та өөрийн хүсэлтээ хэлнэ үү.

Ажлын байрны санал харах зааврын мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.hellowork.mhlw.go.jp/doc/gaikokujinnyuujinnhyounomikata.pdf>



(Япон хэл мэддэг хүн бол) Hello work-н компьютер болон өөрийн компьютер, таблет, ухаалаг утаснаас ч ажлын байрны мэдээллийг хайх боломжтой.

▶▶ <https://www.hellowork.mhlw.go.jp/kensaku/GECA110010.do?action=initDisp&screenId=GECA110010>



(※) Ялангуяа гадаадын иргэнийг дуртайяа хүлээж авах ажлын байр санал болгогчийг хайхыг хүссэн тохиолдолд, “フリーワード” (чөлөөт үг) хэсэгт “外国人” (Гадаад хүн) болон “日本語” (Япон хэл) гэж бичиж оруулбал тохиромжтой.



9 Ажиллахыг хүсэж буй компанидаа өргөдөл гаргаж, ярилцлагад ороорой.

1 Таны хүсэлтэд тохирох ажлын байр олдвол, Hello work-н зөвлөгөө өгөх цонхноос зөвлөгөө авна уу. Hello work нь, компанитай холбогдож, таны ярилцлагын өдрийг товлож, танд “Танилцуулах бичиг” өгнө.

2 Ярилцлагын өдөр хүртэлх хугацаанд, “Намтар” (※1) болон “Ажлын туршлага” (※2)-ыг бичнэ.

Компанийн ажилтан, таны бичсэн намтар болон ажлын туршлага зэргийг үзэж, таныг ажилд авах эсэхээ шийднэ. Ойлгомжтой, нямбай бичиж, өөрийгөө илэрхийлээрэй. Hello work нь, намтар болон ажлын туршлагыг бичих аргыг танд зааж сургах семинар явуулж байгаа. Зөвлөгөө өгөх цонх таны бичсэн баримт бичгийг илүү сайн болгох зөвлөгөөг бас өгч байгаа. Заавал ашиглаарай.

(※1) Та өдий хүртэл хаана суралцсан, хаана ажилласан, яагаад энэ компанид ажиллахыг хүссэн, таны сайн тал, онцлог, мэргэшсэн байдал зэргийг бичих баримт бичиг. Японд, намтартаа өөрийн зургийг наах нь нийтлэг байдаг. Энэ нь “ярилцлагад ирсэн хүн нь үнэхээр та мөн эсэх”-ийг компанийн ажилтан нягтлах зорилготой юм. Таны гадаад төрх, сонголт хийхэд хамааралгүй тул санаа зовохгүй байж болно.

(※2) Та өдий хүртэл хийсэн ажил, өдий хүртэл хийсэн ажлаараа эзэмшсэн ур чадвар зэргээ бичих баримт бичиг.



3 Ярилцлага хүртэл, компанийн тухай мэдээлэл цуглуулж, ярилцлагын дадлага хийнэ. “Яагаад та тэр компанид ажиллахыг хүсэж байгаа вэ”, “та компанид ороод юу хийхийг хүсэж байгаа вэ”, “таны сайн тал болон муу тал юу вэ” гэсэн асуулт нийтлэг тавигддаг. Hello work ярилцлагад бэлдэх семинар явуулдаг. Түүнчлэн, ярилцлагын дэг жаягийн тухай зөвлөгөө болон бодит байдлыг хийсвэрлэсэн дадлага ярилцлага хийдэг.

4 Ярилцлагын өдөр цагт хоцрохгүйн тулд 15-н минутын өмнө очсон байна уу. Hello work-с өгсөн “Танилцуулах бичиг” болон таны өөрийн бичсэн “намтар”-аа марталгүй авч очно уу. Хэрэв, компаниас “баримт бичгээ ярилцлагын өдрөөс өмнө нь компанид ирүүлэхийг хүсэж байна” гэж хэлсэн бол, хугацааг баримтлан илгээх ёстой.

Товлосон өдөр, хэрэв та тогтсон цагаас хоцрохоор тохиолдолд болон гэнэт очиж чадахааргүй тохиолдолд, заавал компанийн ажилтанд утсаар мэдэгдэнэ үү. Товлосон өдөр, компанийн ажилтантай зөв аятай мэндэлж, хувцас болон үс засалт зохистой эсэхээ нягтална уу.


⑩ Ажил хурдан шийдэгдвэл “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авах боломж байдаг.

1 Та “Ажил эрхлэлтийн даатгал”-аас тэтгэмж авах эрхийн баталгаажилт авсны дараа, шинэ ажил хурдан олдвол, “дахин хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж” авах боломжтой байдаг. Hello work руу ажил шийдэгдсэн тухай мэдэгдэл (19-р хуудас) хийсний дараа, ажиллаж эхэлсэн өдрийн дараагийн өдрөөс эхлэн 1 сарын дотор өргөдөл гаргана уу.


2 Тодорхой нөхцлийг хангасан тохиолдолд, дараах мөнгийг авах боломжтой.

Ажилгүйдлийн тэтгэмж авах боломжтой байсан үлдсэн хоног (тэтгэмж авах үлдсэн хоног) нь бүх хоног (тэтгэмж олгохоор тогтоосон хоног)-ийн

- 3-ны 1-ээс илүү тохиолдолд ⇒ таны авах байсан мөнгөн дүнгийн 60%
- 3-ны 2-оос илүү тохиолдолд ⇒ таны авах байсан мөнгөн дүнгийн 70%



- Үндсэн тэтгэмж өдөрт 4,000 иен, тэтгэмж олгохоор тогтоосон өдөр 90 хоног байгаа хүн тэтгэмж авах үлдсэн хоног нь 60 хоног байхад ажилд орсон тохиолдолд



- Тэтгэмж олгохоор тогтоосон хоног 90 хоног байхад, үндсэн тэтгэмжийн үлдсэн хоног нь 60 хоног (3-ны 2-оос дээш) байгаа тул, дахин ажилд орсны тэтгэмжийн олгох хувь нь 70% болно.
- Дахин ажилд орсны тэтгэмжийн мөнгөн дүн нь $4,000 \text{ иен} \times 60 \text{ өдөр} \times 70\% = 168,000 \text{ иен}$ болно.



4

Ажилд орох нь шийдэгдсэн үедээ, бүртгэлээ хийлгэнэ үү.

11 Шинэ компанийн хөдөлмөрийн нөхцлийг шалгаж үзнэ үү.

- 1 Компаниас, таныг ажилд авъя гэсэн мэдээ ирвэл, энэ компанид ажиллая гэж шийдэхээс өмнө, дахин нэг удаа заавал хөдөлмөрийн нөхцлийг шалгана уу.
- 2 “Хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурна уу” гэсэн тохиолдолд, бичсэн байгаа агуулгыг ойлгоогүйгээр гарын үсэг зурахгүй байхыг анхаарна уу.
- 3 Компани нь хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөрийн нөхцлийн мэдэгдэл зэргийг танд өгч, хөдөлмөрийн нөхцлийг мэдэгдэх ёстой. Компанид ажиллах үеийн дүрэм (“Хөдөлмөрийн дотоод журам”)-ийг компани өгөх тохиолдол байдаг.
- 4 Хөдөлмөрийн нөхцөл болон баримт бичиг дээр бичсэн байгаа зүйлийг ойлгохгүй тохиолдолд, компанийн ажилтнаас асууна. Эргэлзээтэй бол, Hello work болон Хөдөлмөрийн стандартын хяналтын газраас зөвлөгөө авах боломжтой.



Хөдөлмөрийн нөхцлийн талаар зөвлөгөө авахыг хүсвэл мэдээллийг эндээс авна уу

▶▶ https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner_eng.html



12 Оршин суух зөвшөөрлийн бүртгэлээ хийлгэнэ үү.

- 1 Таны оршин суух зөвшөөрөл нь 12-р хуудасны 1 байх тохиолдолд Оршин суух зөвшөөрлийн бүртгэл болон Гадаадын иргэн, харьяатын агентлагт мэдэгдэх шаардлагагүй.
- 2 Таны оршин суух зөвшөөрөл нь 12-р хуудасны 2 байх тохиолдолд



Шинэ компанид ажиллах агуулга нь өмнөх компанид ажиллаж байсан агуулгатай өөр тохиолдолд

- 1 Ажлаас гарсан тохиолдолд, Гадаадын иргэн, харьяатын агентлагт “Хамаарах байгууллагын тухай мэдэгдэл”-ээр өмнөх компанитай гэрээ дуусгавар болсон тухай мэдэгдэх ёстой (ажлаас гарснаас хойш 14-н хоногийн дотор).
- 2 Шинэ компани шийдэгдсэн бол, “Оршин суух зөвшөөрлийг өөрчлөх өргөдөл”-ийг Гадаадын иргэн, харьяатын агентлагт гаргах шаардлагатай. Зөвшөөрөл гараагүй бол ажиллаж эхэлж болохгүй. Ажилд орох нь шийдэгдвэл шууд Гадаадын иргэн, харьяатын агентлагт өргөдөл гаргана уу.
- 3 Бүртгэлийг компанийн ажилтан хийж өгөх тохиолдол бас байдаг. Баримт бичгээ өгөхийг өөрөөс чинь хүсвэл шуурхай өгөх хэрэгтэй. Ойлгомжгүй зүйл байвал компани болон Гадаадын иргэн, харьяатын агентлагаас асууна уу.
- 4 Гадаадын иргэн, харьяатын агентлагийн зөвшөөрөл гарвал, ажиллаж эхлэх боломжтой.

Шинэ компанид ижил агуулгын ажил хийх тохиолдолд

Өмнөх компанитай байгуулсан гэрээ дууссан бол (гарснаас хойш 14-н хоногийн дотор) мэдэгдэл хүргүүлэх ёстой. Гадаадын иргэн, харьяатын агентлагт “Оршин суух зөвшөөрлийн өөрчлөлтийн өргөдөл” шаардлагагүй. Шинэ компани шийдэгдсэн бол, шинэ компанитай гэрээ байгуулсан тухай мэдэгдэл хүргүүлнэ үү (ажиллаж эхэлснээс хойш 14-н хоногийн дотор). Гэхдээ зарим нэг “Нарийн мэргэжлийн ажил” болон “Тусгай ур чадвар” зэрэг оршин суух зөвшөөрөлтэй хүн “Оршин суух зөвшөөрлийн өөрчлөлтийн өргөдөл”-ийг Гадаадын иргэн, харьяатын агентлагт гаргах шаардлагатай. Ойлгомжгүй зүйл байвал, Гадаадын иргэн, харьяатын агентлагт хандаж асууна уу.

3

Таны оршин суух зөвшөөрөл нь 13-р хуудасны 3 байх тохиолдолд

Та гадаад оюутан байгаад, сургуулиа төгсөөд шинээр ажиллаж эхлэх тохиолдолд

- 1 Та “Оршин суух зөвшөөрлийн өөрчлөлтийн өргөдөл”-ийг Гадаадын иргэн, харьяатын агентлагт гаргах шаардлагатай. Зөвшөөрөл гараагүй бол ажиллаж эхэлж болохгүй. Ажилд орох нь шийдэгдсэн бол шууд Гадаадын иргэн, харьяатын агентлагт өргөдөл гаргана уу.
- 2 Бүртгэлийг компанийн ажилтан хийж өгөх тохиолдол бас байдаг. Баримт бичгээ өгөхийг өөрөөс чинь хүсвэл шуурхай өгөх хэрэгтэй. Ойлгомжгүй зүйл байвал компани болон Гадаадын иргэн, харьяатын агентлагаас асууна уу.
- 3 Гадаадын иргэн, харьяатын агентлагийн зөвшөөрөл гарвал, ажиллаж эхэлж болно.

Хэрэв та гадаад оюутан болон гэр бүлийн визтэй байгаад шинээр цагийн ажил хийхээр болсон тохиолдолд

Оршин суух зөвшөөрлийн бүртгэл болон Гадаадын иргэн, харьяатын агентлагт мэдүүлэх шаардлагагүй.

Ажиллах цаг 1 долоо хоногт 28-н цаг хүртэл байх ёстойг анхаарна уу. 2-с дээш газар цагийн ажил хийж байгаа тохиолдолд, нийлээд 28-н цагаас хэтэрч болохгүй.

Гадаадын иргэн, харьяатын агентлагийн “Оршин суух зөвшөөрлийг өөрчлөх өргөдөл”-ийн тухай мэдээллийг эндээс авна уу

▶▶ <http://www.moj.go.jp/ONLINE/IMMIGRATION/16-2.html>



Гадаадын иргэн, харьяатын агентлагт мэдэгдэл гаргах бол мэдээллийг эндээс авна уу

▶▶ http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10_00014.html

http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10_00015.html




⑬ Ажил эхлэх үед, бас өөр бусад бүртгэл хийлгэх шаардлагатай байдаг. Мэдэж байгаа юу?

1 Та “Ажил эрхлэлтийн даатгал”-аас мөнгө авч байгаа тохиолдолд, ажиллаж эхлэхээс өмнөх өдөр Hello work руу очиж, ажил шийдэгдсэн тухай хэлнэ үү. Дараах баримт бичгийг авч ирнэ үү.

- Ажил эрхлэлтийн даатгалын тэтгэмж авах эрхийн бичиг (Ажил эрхлэлтийн даатгалын танилцуулах уулзалт дээр өгдөг)
- Ажилгүйдэл баталгаажуулах мэдүүлэг (ажиллаж эхлэх өдөр болон шинэ компанийн хаягийг өөрөө бичнэ.)

2 Компани таны ажиллаж эхэлсэн өдөр болон оршин суух зөвшөөрөл зэргийг Hello work-т мэдэгдэх үүрэгтэй. Компанийн ажилтанд таны оршин суугчийн үнэмлэх дээр бичигдсэн байгаа зүйлийг мэдэгдэнэ үү.



Зөвлөгөө өгөх газруудын жагсаалт

Гэрийнхээ ойролцоох Hello work-г эндээс хайх боломжтой.

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000637894.pdf>



Орчуулагчтай Hello Work бол мэдээллийг эндээс авна уу

▶▶ <https://www.mhlw.go.jp/content/000592865.pdf>



Хөдөлмөрийн нөхцлийн талаар зөвлөгөө авахыг хүсвэл мэдээллийг эндээс авна уу

▶▶ https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner_eng.html

